

“ЗООНОЗЫН ХАЛДВАРЫН ТУЛГАМДСАН АСУУДАЛ” ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ИЛТГЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Монгол улсад зоонозын өвчин судлалын байгууллага үүсэж, хөгжсний 90 жилийн ойд зориулсан “Зоонозын халдварын тулгамдсан асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулагдана.

Зоонозын гаралтай халдварууд, шинэ болон сэргэж буй халдварт өвчин, хайхрагддаггүй өвчин зэрэг сэдвийн хүрээнд гүйцэтгэсэн судалгааны ажлын үр дүнгээ дотоодын болон олон улсын судлаачдад түгээх, туршлага, мэдлэгээ харилцан солилцох зорилгоор эрдэмтэн, судлаач та бүхэн өөрийн илтгэлийн хураангуйг дараах шаардлагын дагуу бичиж ирүүлнэ үү.

Илтгэлийн хураангуйд тавигдах шаардлага:

1. Хурлын илтгэлийг зөвхөн хураангуй (abstract) хэлбэрээр Монгол, Англи хэлээр товч тодорхой бичнэ.
2. Хураангуйн эхэнд бүтээлийн нэр, зохиогчийн нэр, зохиогчийн харъяалагдах байгууллагын нэр, гол судлаачийн и-майл хаягийг бичнэ. Жишээ нь:

БолдГ.¹, Бат Ц.²

¹Шинжлэх ухааны академи

²Зоонозын өвчин судлалын үндэсний төв

e-mail: bold@yahoo.com

3. Үсгийн фонт: Arial, үсгийн хэмжээ 12, мөр хоорондын зай 1 (Single)
4. Илтгэлийн хураангуйг удиртгал, материал, арга зүй, үр дүн, хэлцэмж, дүгнэлт гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг баримтлан боловсруулсан байх ба ном зүйн жагсаалтыг оруулах шаардлагагүй.
5. Монгол, Англи хураангуй нь ижил агуулгатай байх бөгөөд тус бүр 500 хүртэлх үгэнд багтаан бичсэн байна. Түлхүүр үгийг Монгол, Англи хувилбарт адилхан оруулна.
6. Илтгэлийн хураангуйг altantogtokh@nczd.gov.mn болон nczd@nczd.gov.mn цахим хаягаар **2021 оны 6 дугаар сарын 20**-ныг хүртэл хүлээн авна.
7. Хурлын Редакцийн зөвлөл итгэлийн хураангуйг хянан тохиолдуулж сонгон шалгаруулсны дараа илтгэх цагийг баталгаажуулсан хөтөлбөрийг танд илгээх болно.

Холбоо барих: Зоонозын өвчин судлалын үндэсний төв

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, 18131, Сонгинохайрхан дүүрэг 20 дугаар хороо

Утас: +976 70282853, +976 99040664, www.nczd.gov.mn